

“ЭКО-АЗИ” ДЭЭД СУРГУУЛИЙН СУРАЛЦАГЧ ОЮУТАНГ ШАГНАХ, СУРГАЛТЫН ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 “ЭКО-АЗИ” Байгаль орчин, менежментийн дээд сургуулийн $\text{ᠶ᠋ᠢᠨᠯᠠᠭᠠᠨᠠᠶ᠋ᠢᠨᠨᠠᠭᠠᠨᠠᠶ᠋ᠢᠨ}$ бусдыг шагнаж урамшуулах, сургалтын төлбөрийн тэтгэлэг, хөнгөлөлт эдлэх, харилцааг зохицуулна. Энэхүү журам нь сургуулийн тэргүүний шилдэг оюутны хөдөлмөрийг үнэлэх, цаашид сурч боловсрох хүсэл эрмэлзлийг өрнүүлэх, улс орондоо хэрэгтэй сайн боловсон хүчин бэлдэхэд оршино.

Хоёр. Шагнал, урамшил олгох

2.1. Сурлага, урлаг, спорт, бүтээн байгуулалт, багийн зохион байгуулалтаар бусдыгаа манлайлсан оюутанг дээд байгууллагуудын шагналд тодорхойлох, сургуулийн шилдэг, оюунлаг, бүтээлч, оюутанд тодорхойлж, эд зүйл болон мөнгөн хэлбэрийн сургалтын тэтгэлэг олгоно.

- Сурлагаараа 6 улирал дараалан А үнэлгээтэй суралцан, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийн, эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлсэн оюутанд сурлагын төлбөрийн 50 хувийн тэтгэлэг олгоно.
- Сурлагаараа 4 улирал дараалан А үнэлгээтэй суралцан, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийн, эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлсэн оюутанд сурлагын төлбөрийн 30 хувийн тэтгэлэг олгоно.
- “Эко-Ази” Байгаль орчин, менежментийн дээд сургуулийн хэмжээнд /намар 11-р сард/ зохион явагддаг доктор, профессор Ц.Адъяасүрэнгийн нэрэмжит оюутны эрдэм шинжилгээний бага хуралд амжилттай оролцсон оюутанд сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлнэ.

Үүнд:

- 1-р байранд орсон оюутны сургалтын төлбөрийг 20%
- 2-р байранд орсон оюутны сургалтын төлбөрийг 15%
- 3-р байранд орсон оюутны сургалтын төлбөрийг 10%

- Монгол улсын их дээд сургуулиудын дунд зохион явагддаг /хавар 4-р сард/ доктор, профессор Ц.Адъяасүрэнгийн нэрэмжит оюутны эрдэм шинжилгээний бага хуралд амжилттай оролцож, 1,2,3-р байр, тусгай байруудад орсон оюутанд мөнгөн шагнал олгоно.
- Онцгой амжилт гаргасан оюутанд сургалтын тэтгэлэг олгохоос гадна захирлын нэрэмжит цалинг тухай жилийн хөдөлмөрийн хэмжээний доод нөхцөлтэй тэнцэх төгрөгийг сар бүр олгоно.
- Олон улсын тэмцээнүүдэд амжилттай оролцож, эх орон болон сургуулийнхаа нэр төрийг өндөрт авч яваа оюутанд сургалтын тэтгэлэг олгоно.
- Бүтэн өнчин оюутны сургалтын төлбөрийг сурлагын чанараас хамааран 50-100% хөнгөлнө.
- “Сурагчийн холбоо”-той гэрээ хийн тохиролцсоны үндсэн дээр сурах сонирхолтой, амьдарлын бололцоогүй оюутны тодорхойлолтыг үндэслэн 4 жил сургалтын төлбөрийг хариуцан сургалтын төлбөргүй суралцуулна.
- Нэг гэр бүлээс 2 оюутан суралцаж байвал нэг оюутны сургалтын төлбөрөөс 50 хувийг хөнгөлнө.
- Байгаль орчны тогтвортой хөгжилд тодорхой хувь нэмэр оруулж “Ногоон хөгжлийг дэмжих ажил” гүйцэтгэн бүтээн байгуулалтын ажил хийсэн

оюутанд сургалтын төлбөрийн 50-70 хувийн тэтгэлэг олгоно.

- Байгаль орчноо хамгаалах ариун үйлсэд хүчин зүтгэж байгаа нэг байгууллагын 5-аас дээш суралцагч оюутан, байгаль хамгаалагч нарт удирдах дээд байгууллагатай нь гэрээ хийн, сурах таатай нөхцөлийг бүрдүүлэн сургалтын төлбөрийн 10 хувийн хөнгөлөлт үзүүлнэ.